

БАРИМТ НЯГТЛАХ ВЭБ САЙТУУД  
СЭТГҮҮЛ ЗҮЙН ЧУХАЛ ХЭСЭГ БОЛОХ НЬ

Д.Идэржаргал\*

\* МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Нийгмийн ухааны салбарын Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн багш, сэтгүүл зүйн магистр, докторант

**Түлхүүр үг:** баримт нягтлах үйл ажиллагаа; баримт нягтлах вэб сайтууд; түүний бүтэц, хэлбэр, арга зүй, үр нөлөө

**И**нтернет сэтгүүл зүй, сошиал медиа хөгжихийн хэрээр мэдээллийн үнэн бодит байдалд аюул заналхийлэх болсон. Мэдээллийн хэмжээлшгүй хурд үнэн зөвийг нягтлах боломжийг хязгаарлах болсон нь мэдээлэл харилцааны салбарт хөгжил ухралт ч авчирч болох нь гэсэн эргэлзээг төрүүлж байсан юм. Шинэ мэдээлэл олсон даруйдаа түгээхгүй бол аль хэдийн хуучин болчихдог практик мэдээллийн агентлагуудыг зовоож, энэ хэрээрээ баталгаагүй, худал мэдээллүүд сошиал ертөнц, Интернет сэтгүүл зүйд нэмэгдэх болсон. Харин энэхүү сорилтыг даван гарч буй барууны орнуудын шийдэл нь баримт нягтлах вэб сайтууд (fact-checking websites) болж байна.

Уламжлалт сэтгүүл зүйд өдөр тутмын практик байсан баримт нягтлах явдал нь Интернет сэтгүүл зүйн эрин үед харьцуулшгүй чухал ач холбогдолтой ойлголт болж байна. Үүнийг тайлбарлахын тулд эхлээд “Баримт

нягтлах гэж юу вэ?” гэсэн асуултанд хариулъя. Википедиад тайлбарласнаар “Баримт нягтлагч гэдэг нь уран зохиолын бус буюу ихэвчлэн тогтмол хэвлэл, олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд хэвлэгдэх текстэнд агуулагдаж буй баримт бүхий мэдээллүүдийг нягталдаг хүн бөгөөд тэдгээр баримтуудын үнэн бодит байдлыг шалгаж, шаардлагатай тохиолдолд засварладаг”<sup>1</sup> гэжээ. Албан ёсны бас зөв тодорхойлолт. Тогтмол хэвлэлүүд, өдөр тутам, сар тутмын гэж ялгагдахгүйгээр нийтлэлүүдийнхээ агуулгыг хянаж байх ёстой. Хүн, газар орны нэрийг нягтлахаас эхлээд ярилцагч ингэж хэлсэн гэж сэтгүүлчийн бичсэн нь үнэн эсэхийг хүртэл баталгаажуулна. Энэ чухал үйл ажиллагааг 1920-иод оны үеэс Америкийн “Time” болон “New Yorker” сэтгүүлүүд анх системтэйгээр эрхлэх болжээ. Ихэвчлэн эмэгтэйчүүд баримт нягталдаг байсан ба дээрх сэтгүүлүүдийн нэр хүндийг огцом өргөж байв. Удалгүй энэ практик “Guardian”, “Wall Street Journal”-аас эхлээд бусад алдартай хэвлэлүүдэд нэвтэрсэн.

Харин Интернет сэтгүүл зүйн үеийн баримт нягтлах ажиллагаа (ялангуяа

улс төрийн баримт нягтлал) уламжлалт сэтгүүл зүйнхээс илүү өргөн хүрээнд яригдаж байна.

**Бүтцийн хувьд** баримтыг редактор гэхээсээ илүү тодорхой байгууллага нягталдаг боллоо. 2003 оноос бүгд биш боловч дийлэнх нь АНУ-д эхэлсэн олон Интернет төсөл (вэб сайт) маргаантай мэдээ, баримтуудыг нягталж эхэлсэн байна. Тэдний анхдагч нь болох *Factcheck.org*-ийг Пенсилванийн Их Сургуулийн дэргэдэх Анненбергийн Нэрэмжит Олон Нийтийн Бодлогын Төв үүсгэн байгуулжээ. Сэтгүүлч, редакторуудаас бүрдсэн баг сонинуудын улс төрийн нийтлэлийн хандлага болон баримтуудыг нь нягталж эхэлжээ.

**Ү**үний дараа *Fackcheck.org* сайт байгуулагдсан бөгөөд улс төрийн сонгуульд нэр дэвшигчдийн видео зар сурталчилгаан дахь баримтууд үнэн зөв эсэхийг нягталсан байна. 2007 онд баримт нягталдаг хоёр шинэ сайт гарч ирсэн нь “Washington Post”-ийн *FactChecker* болон “Tampa Bay Times”-ийн *PolitiFact*-ууд байлаа. Америкийн сэтгүүл зүй дэх шинэ чиг хандлага Европын орнуудад хурдтайгаар халдварлав. 2010 оны наймдугаар сард “Guardian” агентлаг *Pledge Tracker* сайтаа үүсгэн байгуулсан бөгөөд Холбооны Засгийн газрын 400 гаруй амлалтын хэрэгжилтийг нягталж эхэллээ. Италид *Pagella Politica*, Их Британид олон нийтийн мэтгэлцээнийг нягтлах зорилготой *FullFact.org* байгуулагдсан байна. 2012 онд Германд “Der Spiegel” *Münchhausen-Check* сайтаа, араас нь “Die Zeit” сүлжээ *Faktomat*, “ZDF” телевиз *ZDFcheck*-ийг үүсгэн байгуулжээ. Швед, Голланд, Дани ч мөн үүнийг тойрсонгүй.

Зөвхөн Францаар жишээ татахад анхны баримт нягталдаг сайтыг 2008

онд “Libération” сонин *Désintox* нэртэйгээр нээв. 2009 онд “Le Monde” сонины *LesDécodeurs* байгуулагдсан бол дараагийн 3 жилд *Les Pinocchios*, *Le Nouvel Observateur*, *Le Vêritometre* болон телевизийн сүлжээний эрхэлдэг *Télé*, *Le Vrai du Faux*, хувийн мэдээллийн сүлжээний *Facta Media*, онлайн хаб *Les Observateurs* байгуулагдаж, бүр радио сүлжээ “Europe1” болон “France24” телевиз хүртэл баримт нягталдаг хөтөлбөртэй болжээ.

2015 оны байдлаар олон улсын хэмжээнд идэвхитэй үйл ажилладаг баримт нягтлах вэб сайтын тоо 64 болсон нь өмнөх жилийнхээс 20-иор нэмэгдсэн үзүүлэлт юм<sup>2</sup>. Дээрх баримтууд нь барууны хөгжингүй орнуудад энэ төрлийн вэб сайтууд трэнд болж байгааг баталж чадна. Эдгээр сайтууд дийлэнх нь улс төр, эдийн засаг, хууль, олон нийтийн бодлого, шинжлэх ухаан, хэвлэл мэдээллийн хэрэгслүүд болон бусад төрөлжсөн чиглэлээр баримт нягталж байна.

Өнөө үед сэтгүүл зүйн баримт нягтлах үйл ажиллагаа нь сэтгүүл зүйн бие даасан байгууллага эсвэл салбарын шинэ хандлага хэмээн үзэгдэхээр өргөн бүтэцтэй болжээ. Уламжлалт үеийнх шиг ганц редактор бус бүхэл бүтэн баг, байгууллага, судлаач, сэтгүүлч, салбарын мэргэжилтнүүд баримт нягталдаг болсон.

Зөвхөн ажиллах хүчний хувьд ч биш зорилгын хувьд ч баримт нягтлал илүү өргөн утгатай болсон. Уламжлалт сэтгүүл зүйд баримт нягтлал сэтгүүлч алдаа гаргахаас сэрэмжлэх, олж авсан мэдээллээ баталгаажуулах зорилготой байсан бол Интернет сэтгүүл зүйн баримт нягтлал илүү нийгмийн шинж чанартай, тодорхой зорилготой болсон байна. Тухайлбал, Америкт

*FactCheck.org* болон *PolitiFact*-ийг үүсгэн байгуулагч, сэтгүүлч Билл Адайр “*PolitiFact*-ийн гол зорилго нь бие хүмүүсийн худал ярихыг зогсоох огт биш харин мэдээллийн зах зээлд нягт үнэнийг түгээснээр ардчиллыг хүчирхэгжүүлэх зорилготой”<sup>3</sup> гэжээ. Их Британид *Full Fact* сайтыг үүсгэн байгуулагч Вилл Моу сайтынхаа үр нөлөөг тодорхойлохдоо “Алдаанд хүргэж буй системийг засах” хэмээн тодорхойлжээ. Өөрөөр хэлбэл *Full Fact* худал мэдээлэл түгээхийг зогсооно, багасгана гэж үздэг бөгөөд улс төрчдийг алдаатай мэдээллээ заавал залруулахыг лоббиддог байна.

**Хэлбэрийн хувьд** вэб сайтад суурилсан баримт нягтлах үйл ажиллагаа илүү ойлгомжтой, олон хэлбэрээр явагдаж байна. Вэб сайт баримт нягтлалд дараах таван гол онцлогийг авчирсан хэмээн “Ройтерс” хүрээлэнгийн судлаачид үзжээ<sup>4</sup>. Эдгээр нь:

- Шууд нягтлал
- Нээлттэй дата

- Төвлөрсөн эх сурвалж
- Контентын семантик анализ
- Тоглоомчлол болно.

Live fact-checking буюу шууд нягтлал нь баримтыг тухайн цаг үед нь түргэн шуурхай нягталж түгээхийг хэлнэ. Тухайлбал, өнгөрсөн 10 дугаар сард Америкийн Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдийн (Дональд Трамп, Хиллари Клинтон) нарын 2 дахь халз мэтгэлцээнийг “NPR” агентлагийн баримт нягтлах баг сурвалжилжээ. Улс төр, эдийн засаг, бизнес, олон улсын харилцаагаар мэргэшсэн сэтгүүлчдийн баг мэтгэлцэгчдийн хэлсэн өгүүлбэр, баримт бүхнийг хэрхэн шууд нягталсныг дараах зургаас харж болно<sup>5</sup>. Энэ бол мэтгэлцээнтэй хамт өндөр хурдаар хийгдэж буй баримт нягтлал юм. Өнөө үед Twitter шууд баримт нягтлалыг хүргэх гол сүлжээ болсон. Шууд дамжуулалт дууссаны дараа илүү гүнзгий өгүүллийг баримт нягталдаг вэб сайтууд дүгнэлт маягаар оруулдаг.

When I look at all of the things that I see and all the potential that our country has, we have such tremendous potential, whether it's in business and trade where we're doing so badly.

The United States consistently has run [trade deficits](#) since 1976, primarily because of large imports of oil and low-cost consumer products.



**Marilyn Geewax**  
NPR Senior Business Editor

Last year we had an almost [800 billion dollar trade deficit](#).

The 2015 [foreign trade deficit](#) was \$531.5 billion.



**Marilyn Geewax**  
NPR Senior Business Editor


Зураг 1. Дональд Трампын “2015 онд АНУ-ын гадаад худалдааны алдагдал 800 тэрбум доллар байсан” гэх мэдээдлийг сэтгүүлч худал гэж үзсэн бөгөөд 531.5 тэрбум доллар байсан хэмээн залруулжээ

Дата мэдээллийн тухайд албан ёсны институтууд (Дэлхийн банк, Олон Улсын Валютын Сан) гаргадаг бөгөөд бүх хүнд нээлттэй форматаар (ойлгомжтой, ашиглахад бэлэн формат) цацсанаар сэтгүүл зүйн эрэн сурвалжлах үйл ажиллагаа уламжлалт үеийнхээс харьцангуй бага цаг, хөрөнгө шаардсан ажил болжээ. Баримт нягтлагчид нээлттэй датануудыг ашиглаад зогсохгүй өөрсдөө нээлттэй датаны эх сурвалж болдог. Тодорхой асуудлаар нягталсан үнэн бодит баримтууд нь тухайн сэдвээр бичдэг сэтгүүлчдэд, уншигчдад төвлөрсөн эх сурвалж болдог. Энэ тохиолдолд төвлөрсөн мэдээллийг эрэмбэлэх, хайх боломжийг зөвхөн Интернет л олгож чадна.

Контентын семантик анализ нь баримт нягтлагчдын дүгнэлт бодит байдалд нийцэж байгаа эсэхийг тодорхойлно. Өөрөөр хэлбэл нягталсан мэдээлэл нь үнэн гэдгийг батлах эх сурвалжаар хангаж өгдөг. Энэ эх сурвалж нь улс төрчийн видео ярилцлага, нээлттэй дата гэх мэтчилэн мэдээллийг шалгахад ашигласан

линкүүд байна. Дийлэнх баримт нягтлах вэб сайтуул тэдгээр холбоосуудыг нээлттэй зарладаг тул уншигчдын итгэл үнэмшил баталгааждаг.

Gamification буюу тоглоомчлол нь хүлээн авагчдад баримтыг илүү энтертайнмент түвшинд хүртэх боломжоор хангаж байна. Тухайлбал, мэдээ баримтыг тест, таавар, мэдээний тоглоомон аппликэйшн хэлбэрээр хүлээн авч болох бөгөөд энэ зуур улс төрчдийн амлалт биелэсэн эсэхийг эрэмбэлдэг байх жишээтэй. Өөрөөр хэлбэл визуаль сэтгүүл зүйн элементүүдийг ашиглах болсноор уншигчдын цаг хугацааг хэмнэх, зугаацуулах давуу талуудыг авчирч байна. Америкийн хамгийн алдартай баримт нягтлагч *PolitiFact* сайт л гэхэд улс төрчдийн мэдэгдлийг “Truth-O-Meter” буюу “Үнэний тооцооллуур” гэгчээр хэмждэг. Энэ хэмжигдэхүүн үнэн, дийлэнх нь үнэн, хагас нь үнэн, дийлэнх нь худал, Pants on fire буюу худалч гэсэн 5 түвшинтэй бөгөөд тэдгээрийг визуаль хэлбэрээр хүргэж буйг доорх зургаас харж болно<sup>6</sup>.



Зураг 2. *PolitiFact* сайт “Үнэний тооцооллуур”-аас ямар улс төрч хамгийн олон удаа худал ярьж, худалч түвшинд тоологдсоныг харуулжээ

Түүнчлэн “Washington Post” сонины *Fact Checker* сайт ‘Pinocchio’ гэсэн хэмжүүр гаргасан бөгөөд улс төрчдийг худал хэлэх тоолонд нь тэдний үзүү-

лэлт дээр нэг урт хамарт хүүхэлдэй нэмдэг. Олон нийтэд таалагдсан энэ хэмжүүрийн дүгнэлт болгож “2016 оны сонгуулийн хамгийн урт хамартай

Пиноккио”<sup>7</sup> өгүүлэл нийтлэгдсэн нь ихээхэн шуугиан тарьж байв. Эдгээр жишээнүүд нь баримтуудад гүн гүнзгий анализ хийхээс гадна тоглоомчлолын аргаар хүнд хүргэх ёстойг харуулж байгаа юм.

Баримт нягталдаг вэб сайтууд **ямар арга зүйгээр** ажилладаг бөгөөд хэр үр нөлөөтэй тухай *PolitiFact* сайт дээр жишээ татая.

*PolitiFact* сайт нягталсан баримтуудаа олон нийтэд нээлттэй домэйн хаягт байршуулдаг тул үүнийг хүссэн хүн бүр хүлээн авах боломжтой. Нягтлагчид улс төрчдийн мэдэгдлийг судалж, үнэн бодит эсэхийг нь Truth-O-Meter-ээр хэмждэг бөгөөд хамгийн худал мэдээллийг “Pants on Fire” буюу “огтоос худал” гэж тэмдэглэдэг. Нягтлагчид баримтыг судалсны дараа гаргасан дээрх хэмжүүр үнэн зөв эсэхийг багадаа 3 редакторын бүрэлдэхүүнтэй баг дахин хянадаг байна. Тэд сонгосон албан тушаалтан, улс төрийн намын лидер, улс төрийн тэмцэгч, тэдэнтэй хамтардаг вэб сайт, улс төрд холбоотой бүлглэл болон улс төрийн гүйцэтгэх хороодын мэдээллийг нягталдаг.

Аль мэдэгдлийг нягтлах вэ гэдгийг сонгохдоо *PolitiFact*-ийн ажилчид

тодорхой, мөнхийн сэтгэгдэл үлдээж болохуйц баримтуудыг сонгодог. Эдгээрийг улстөрчдийн илтгэл, мэдээ, зар сурталчилгаа, социал хаягуудаас нь олдог аж. Мэдээж улс бүх баримтыг нягтлах боломжгүй учраас илүү чухал ач холбогдолтой буюу мэдээллийн зах зээлд маш ихээр нөлөөлж буй болон нягтлагдахгүй хоцорвол сөрөг нөлөө үзүүлж чадах хүчирхэг баримтуудыг сонгох зарчимтай.

**Б**аримтыг нягтлахдаа улс төрчийн ярилцлагууд, Интернет дэх нээлттэй мэдээллүүдийг ашигладаг. Баримт нягтлал болгоны төгсгөлд *PolitiFact* эх сурвалжуудаа линктэй нь хамт цацдаг тул уншигчдад итгэл үнэмшил төрүүлж чаддаг.

Хадаас материалаа сайтдаа онцолдог бөгөөд маш том хэмжээтэй бичвэр болдог аж. Үнэн, дийлэнх нь үнэн, хагас нь үнэн, дийлэнх нь худал, худал гэсэн түвшинтэй “Үнэний хэмжүүр”-ийг визуаль түвшинд хүлээн авах боломжтойгоор зохион байгуулжээ.

Үнэн зөвийн шүүлт хийгдсэний дараа *PolitiFact* олон нийтэд анализ бүхий нийтлэл хүргэдэг. Түүнчлэн нягталсан баримтуудыг Facebook, Twitter-т түгээх шууд холбоосор хангаж өгдөг.



Зураг 3. Дональд Трампын энэхүү мэдээгдэл огт худал гэсэн түвшинд ангилагдсаныг цааш түгээх боломжийг харж болно

Үр нөлөөний тухайд баримт нягтлах үйл ажиллагаа харьцуулшгүй өргөн болжээ. Тухайлбал, *PolitiFact* сайт АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдийн баримтуудыг нягталсан нь олон нийтийн анхаарлыг их татсан юм. Бүгд Найрамдах намын анхдагчид ерөнхийлөгчид нэр дэвшихийн төлөө нам дотроо үзэлцэж, өрсөлдөгчдөө худалчаар нь дуудаж эхэлсэн нь тэдний баримтыг нягтлахаас аргагүйд хүргэжээ. Тед Крузийн кампанит ажлын уриа “Үнэний цаг ирсэн” байсан бол

Дональд Трампын баннерууд “Худалч Тед Круз” гэсэн байв. Харамсалтай нь тэдний хэн ч хангалттай үнэн байгаагүйг *PolitiFact* тогтоожээ. Тед Крузийн мэдэгдлээс 114-ийг шалгасан бөгөөд 65 хувь нь дийлэнх нь худал, худал ангилалд багтаж байв. Марко Рубиогийн мэдэгдлүүдийн 51 хувь нь худал болох нь тогтоогджээ. Харин

Дональд Трампын 158 мэдэгдлийг нягтлахад 76 хувь нь дийлэнх нь худал, худал, ангилалд багтаж байв. Ерөнхийлөгчийн сонгуульд түүнтэй ширүүн өрсөлдсөн Хиллари Клинтонь 136 мэдэгдлийн 27 хувь нь дийлэнх нь худал, худал ангилалд оржээ. Берни Сандерсын 106 мэдэгдлийн 21 хувь нь дийлэнх нь худал, худал ангилалд орсон ч байна.

Ерөнхийлөгчийн сонгуулийн кампанит ажлын хугацаанд Дональд Трамп 18 удаа огт худал баримт ярьсан нь тоон чанарын хувьд түүнийг хамгийн худалч болохыг баталж байю.

Тухайлбал, 2015 оны долдугаар сард Трамп христийн шашинтай сириудыг АНУ-д амьдрахыг хүлээн зөвшөөрдөггүй байсан хэмээн ярьжээ. *PolitiFact* баримт нягталсны дараа христийн шашинтай цагаачдыг огт ялгаварладаггүй байсныг тогтоосон байна. 2015 оны есдүгээр сарын 28-нд тэрээр АНУ-ын ажилгүйдлийн түвшин 42 хувиас өндөр байна гэж ярьсан нь үнэн болох нь тогтоогджээ. 11 дүгээр сарын 21-нд Трамп Нью Жерси хотод олон мянган исламчууд Дэлхийн худалдааны төвийг

нураа хэмээн орилж буй бичлэг үзсэн гэж ярьсан ч тийм бичлэг огт олдоогүй байна. *PolitiFact* Трампыг “2015 оны худалч хүн” хэмээн цоллосон ч тэрээр намаасаа ерөнхийлөгчид нэр дэвшихээр болж, дараа жил нь сонгуульдаа ч ялалт байгууллаа. Гэхдээ энэ үр дүн өөр хүчин зүйлүү-

дээс хүчтэй хамааралтай нь ойлгомжтой юм. Ямар ч байсан баримт нягтлах үйл ажиллагаа Интернетийн ачаар субъект болон хувирч, өөрөө мэдээллийн эх сурвалж, үнэн зөвийг ялгагч болж цаашлаанд худал ярьдаг улстөрчдийн сонголтод хүртэл нөлөөлж байна. Ингэснээр улс төрчид хэлэх үг, ярих илтгэл, амлалтандаа хүртэл илүү няхуур хандах болжээ.

*PolitiFact* сайтын хандалт 2016 оны эхний таван сард 2015 оны мөн үеийнхээс 128 хувиар өссөн нь тус сайтыг хэр үр нөлөөтэй болсныг илтгэнэ. Мөн 2009 онд тус сайт

«

***PolitiFact* сайт нягталсан баримтуудаа олон нийтэд нээлттэй домэйн хаягт байршуулдаг тул үүнийг хүссэн хүн бүр хүлээн авах боломжтой. Нягтлагчид улс төрчдийн мэдэгдлийг судалж, үнэн бодит эсэхийг нь Truth-O-Meter-ээр хэмждэг бөгөөд хамгийн худал мэдээллийг “Pants on Fire” буюу “огтоос худал” гэж тэмдэглэдэг**

»

“Үндэсний сурвалжлага” номинацид нэр дэвшиж Пулитцерийн шагнал хүртэж байсан билээ.

**Б**үтэц, баримт бэлдэх арга зүй, хэлбэрийн ялгааг үл харгалзан баримт нягтлах вэб сайтууд нь сэтгүүл зүйн чухал хандлага болж байна. Тэдгээр нь үнэн зөвийг нягтлаад зогсохгүй мэдлэг бүтээж, сэтгүүл зүйг эрүүлжүүлж, олон нийтийн санаа бодолд нөлөөлж буй хүчирхэг үр нөлөөтэй үйл ажиллагаа юм. Мөн социал медиагийн эрин үе дэх сэтгүүл зүйн тулгамдсан асуудлуудын нэг болох худал, батлагдаагүй мэдээлэлтэй тэмцэх гол арга зам болж байна. Ирээдүйд баримт нягтлах вэб сайтууд контентуудаа хэрхэн визуальчлах, түгээх асуудал чухалд тооцогдох болно.

#### Ишлэл

<sup>1</sup> [https://en.wikipedia.org/wiki/Fact\\_checking](https://en.wikipedia.org/wiki/Fact_checking)

<sup>2</sup> <http://reporterslab.org/snapshot-of-fact-checking-around-the-world-july-2015/>

<sup>3</sup> <http://www.li.com/activities/publications/facts-we-can-believe-in-how-to-make-fact-checking-better>

<sup>4</sup> <https://reutersinstitute.politics.ox.ac.uk/ckfinder/userfiles/files/342-From-traditional-to-online-fact-checking.pdf>

<sup>5</sup> <http://www.npr.org/2016/10/09/497056227/fact-check-clinton-and-trump-debate-for-the-second-time>

<sup>6</sup> <http://www.politifact.com/personalities/donald-trump/>

<sup>7</sup> [https://www.washingtonpost.com/news/fact-checker/wp/2016/11/04/the-biggest-pinocchios-of-election-2016/?utm\\_term=.4bde4404f60b](https://www.washingtonpost.com/news/fact-checker/wp/2016/11/04/the-biggest-pinocchios-of-election-2016/?utm_term=.4bde4404f60b)

#### Ашигласан бүтээлийн жагсаалт

1. *Shawcross Alistair*. Facts we can believe in: How to make fact-checking better. 2016. Legatum Institute.

2. *Mantzaris Alexios*. There Are 96 Fact-Checking Projects in 37 Countries, New Census Finds, *Poynter*, February 16, 2016. [www.poynter.org/2016/there-are-96-fact-checking-projects-in-37-countries-new-census-finds/396256](http://www.poynter.org/2016/there-are-96-fact-checking-projects-in-37-countries-new-census-finds/396256), accessed 28 July, 2016.

3. [www.politifact.com](http://www.politifact.com)

4. [www.washingtonpost.com](http://www.washingtonpost.com)

5. [www.npr.org](http://www.npr.org)

#### Summary

In this article, we have considered differences of “fact-checking” concept in traditional and online journalism. Also, we have documented the growth of fact-checking sites across America and Europe. An increasing number of fact-checking outlets exist, and across different countries, different organizational forms, and different self-identified orientations, they share a common commitment to publicly evaluating the truth claims made by powerful actors like politicians and in some cases news media. Despite differences in how they work, how they communicate their findings, and how they are funded, they identify with a broader international movement. “Fact-checking” has become an increasingly popular way to fight back against the deluge of disinformation.